



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 3 сарын 05 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Томилолтоор ажиллуулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тогтоол, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сангийн хамтран баталсан “Санхүүгийн боловсрол түгээх сургагч багш бэлтгэх” сургалт зохион байгуулах удирдамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Өмнөговь, Дундговь аймгуудад 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хооронд “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх сургалт” зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, томилолтод шаардагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Томилолтоор ажилласан талаарх илтгэх хуудсыг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг /Б.Шинэжаргал/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар /Б.Батзориг/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М. ӨЛЗИЙБАТ

Ажлын албаны даргын 2019 оны
3 дугаар сарын 05-ны өдрийн
57 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**ӨМНӨГОВЬ, ДУНДГОВЬ АЙМГУУДАД “ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ЗОРИУЛСАН
САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ”
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Шинэжаргал

Банк бус санхүүгийн байгууллагын газрын референт

Ажлын хэсгийн гишүүд:


Ц.Дашням

Даатгалын газрын ахлах мэргэжилтэн

Ц.Хонгорзул

Үнэт цаасны газрын мэргэжилтэн

Ажлын албаны даргын 2019 оны
3 дугаар сарын 4-ны өдрийн
57... дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ӨМНӨГОВЬ, ДУНДГОВЬ АЙМГУУДАД “ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ЗОРИУЛСАН
САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ” ХИЙХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. Томилолтын зардал:

№	Аймаг	Ажилтны тоо	Ажиллах хоног	Нэг хоногийн томилолтын зардал	Нийт дүн	Хянасан
1	Өмнөговь	3	4	50,000	600,000	
2	Дундговь	3	3	50,000	450,000	
	Нийт		7		1,050,000	

Хянасан:

Ерөнхий нягтлан бодогчийн
үүргийг түр орлон гүйцэтгэгч

/Б.Жаргалцэцэг/

Боловсруулсан:

ҮЦГ-ын мэргэжилтэн

/Ц.Хонгорзул/